

## Төлөвлөгөө



Эрэлтэд суурилсан төсөл хөтөлбөр сонгон шалгаруулж, хэрэгжүүлэх зарчмынхаа дагуу АМЕП 2 Монголын эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, түүнд хувь нэмэр оруулах санал санаачлагыг хамтрагч нартайгаа тодорхойлж байна.

2020-21 онд хийх ажлын төлөвлөгөө боловсруулах үйл явцыг энэ оны 4 дүгээр сараас эхлүүлж, 21 байгууллагаас 48 төсөл, хөтөлбөрийн санал хүлээн аваад байна. “Хамтран ажиллагч байгууллагууд дунд эрдэс баялгийн салбар дахь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах шаардлага, сонирхол маш өндөр байгааг харахад таатай байна. Бид эдгээр 48 төслийн саналаас хамтын зорилго, зорилгод нийцсэн 5, 6 төсөл шалгаруулж, АМЕП 2-ын Зөвлөх хороонд хүргүүлнэ. Эцсийн шийдвэрийг МУ-ын Засгийн газар болон Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам гаргана” хэмээн АМЕП 2 Хөтөлбөрийн удирдагч Кирстен Ливермор хэлсэн юм.

МУ-ын эрдэс баялагт суурилсан эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад дэмжлэг үзүүлэх зорилготой АМЕП 2 хөтөлбөр 2019 оны 4 дүгээр сараас өнөөг хүртэл хийж гүйцэтгэсэн ажлаа хөтөлбөр тус бүрээр танилцуулж байгаадаа баяртай байна.

## 1. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний МОНВАЛ кодекс

- Монгол Улсын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний кодекс боловсруулах, бусад дүрэм журамтай уялдуулан хэрэгжүүлэх 15 гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Санхүүгийн зохицуулах хороон дээр байгуулагдлаа. Ажлын хэсэгт Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Монгол банк, Хөрөнгийн бирж зэрэг байгууллагын төлөөлөл багтсан. МОНВАЛ 2020 кодекс, холбогдох хуулиудад хийсэн тайлан илтгэлтэй ажлын хэсгийн гишүүд танилцан, санал зөвлөмжөө ирүүлж байна. Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж, сэтгүүлчид, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн зэрэг оролцогч талуудтай мэдээлэл хуваалцах, сургалт сурталчилгаа мөн зохион явууллаа. МОНВАЛ болон Эрдэс баялаг, хүдрийн нөөцийг олон нийтэд мэдээлэх Монгол улсын кодекс танилцуулах сургалт уулзалтуудад 30 орчим геологич, олон улсын хөрөнгийн үнэлгээний кодексийн сургалтад Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтын 20 үнэлгээч хамрагдаад байна. ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургуульд мөн МОНВАЛ кодексийг танилцуулсан болно.
- Олон улсын зөвлөх Стив Гемелл ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ хийх олон улсын туршлага, Олон улсын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний загвараар өөрийн хөрөнгийн үнэлгээний кодекс боловсруулсан таван улсын жишээг Монголын төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн төлөөлөлд танилцуулж, сургалт уулзалт зохион байгууллаа. Санхүүгийн зохицуулах хороо, ажлын хэсэгт Олон улсын хөрөнгийн үнэлгээний загвар, туршлагуудын талаарх бүх мэдээллийг англи, монгол хэлээр хүргүүлээд байна.

## 2. Техник, эдийн засгийн үндэслэл

- Монгол улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас (УУХҮЯ) тавьсан хүсэлтийн дагуу Техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) боловсруулах, түүнийг хүлээн авах, хянан нягтлах, хэрэгжүүлэхтэй холбоотой журмыг шинэчлэхэд техникийн туслалцаа үзүүлэн ажиллаж байна. АМЕП 2- ТЭЗҮ боловсруулах, хүлээн авах, хянах, хэрэгжүүлэхтэй холбоотой олон улсын харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэлээ.
- УУХҮЯ-ны Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Мөнхтөрөөр ахлуулсан 16 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдлаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд АМЕП 2, Ашигт малтмал газрын тосны газар, Ил уурхайн инженерүүдийн холбоо, Монголын уул уурхайн зураг төсөл зохиогчдын холбоо, ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургууль, Уул уурхайн аврах анги, Монголын ашигт малтмал баяжуулагчдын холбоо, Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны төлөөлөл багтжээ. ТЭЗҮ-ийн талаарх суурь ойлголт, үндсэн танилцуулга, Монгол дахь дүрэм журмыг олон улсын сайн туршлагатай харьцуулсан үнэлгээ зэргийг АМЕП 2 хөтөлбөрийн хүрээнд боловсруулж, ажлын хэсэгтэй хамтран ажиллаж байна.
- АМЕП 2-оос зохион явуулсан “ТЭЗҮ-ийн олон улсын сайн туршлага” мэдээлэл солилцох уулзалтад УУХҮЯ-ны 4, Монголын уул уурхайн зураг төсөл зохиогчдын холбооны 16, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 10 мэргэжилтэн хамрагдлаа. Мөн төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн 30 төлөөлөл оролцсон дугуй ширээний уулзалтаар ТЭЗҮ-тэй холбоотой одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль дүрмийн давуу болон сул тал, тулгарч буй сорилт бэрхшээлийн талаар ярилцсан. Эдгээр уулзалт, зөвлөгөөний үеэр гарсан санал зөвлөмжийг нэгтгэн, хууль дүрмийн шинэчлэл хийхдээ харгалзан үзэхийг холбогдох газруудад нь уламжиллаа.

# 2019-20 онд АМЕП 2-ын хийсэн ажлын тайлан (үргэлж.)

## 3. Үнэ шилжүүлэлтийн дүрэм

Австрали, Монгол улсын татварын ерөнхий газрын хооронд стратегийн хамтын ажиллагаа тогтооход АМЕП 2 туслан ажиллаж байна. Энэ хамтын ажиллагааны хүрээнд Австралийн татварын албаны мэргэжилтэн Монголын Татварын ерөнхий газрын холбогдох мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж, үнэ шилжилтийг зохицуулсан шинэ дүрэм журмыг хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэх талаар туршлага хуваалцана.

## 4. МонГеоКат систем

АМЕП хөтөлбөрийн геологичид Монголын геологийн мэдээллийн каталогийн сан буюу mris.mn цахим хуудсанд 452 тайлан мэдээлэл нэмж орууллаа. Монголд хийгдсэн геологи, ус, эрдэс баялгийн эрэл хайгуулын мэдээллийн хураангуйг дэлхийн хаанаас ч англи, монгол хэлээр авах боломжтой. 2017 оны 8 дугаар сард нээгдсэнээс хойш тус цахим хуудсанд нийт 119 мянган хэрэглэгч нэвтэрч, мэдээ мэдээлэл авчээ. Эдгээрийн 13 мянга нь дотоодоос, харин 2,083 хэрэглэгч 59 орноос хандсан байна.

## 5. Нүүрсний давхаргын метан хий

УУХУЯ, Ашигт малтмал, газрын тосны газар, салбарын мэргэжилтнүүд нүүрсний давхаргын метан хийн хайгуул, боловсруулалтын зохицуулалт, эрх зүйн орчны туршлага судлах хүсэлтээ АМЕП 2-т илэрхийлсний дагуу Австралийн Куинслэндийн их сургуулийн Байгалийн хийн судалгааны төвтэй хамтран ажиллах эхлэлийг тавилаа.

## 6. Нягтлах бодох бүртгэл стандарт

Уул уурхайн компаниуд уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн сан үүсгэж, түүнийгээ Сангийн яамны баталсан стандартын дагуу санхүүгийн тайландаа тусгах үүрэгтэй. АМЕП 2 аудитын тэргүүлэх фирм болох KPMG-г гэрээлэн, Хайгуул болон олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандартыг хэрэгжүүлэхэд нь Сангийн яамны холбогдох хэлтэс, мэргэжилтнүүдэд зөвлөн ажиллаж байна.

АМЕП 2 дээрх хөтөлбөрүүд дээр үргэлжлүүлэн ажиллахын зэрэгцээ ирэх жилийн ажлаа төлөвлөж байна. Бидэнтэй холбогдож, төслийн санаа бодлоо хуваалцаарай. ■

## Зөвлөлдөх уулзалтууд

2020 оны 4, 5 дугаар сард АМЕП 2 хөтөлбөрийн баг зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгууллаа. КОВИД-19-ийн тархалтаас сэргийлэхийн тулд уулзалтуудыг цахимаар хийж, мөн зарим тохиолдолд зохих зайг барин, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн салбарын төлөөлөгч нартайгаа уулзаж, хамтран ажиллах боломжуудын талаар зөвлөлдлөө.

